



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 1/25

Булган

Шинэ коронавирусийн эрсдлээс  
урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.а, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 30 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны гуравдугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан олон нийтийг хамарсан хурал цуглаан, сургалт, уулзалт зөвлөгөөн, соёл, урлаг, спортын нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах болон тоглоомын газруудын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд 2020 оны 03 сарын 02-ны өдрийг дуустал хугацаанд түр хориглосугай.

2. Шинэ коронавирусийн халдварын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар бүх нийтэд үнэн, зөв мэдээллийг шуурхай хүргэж байхыг Эрүүл мэндийн газар /С.Нарантуяа/-т, халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, сэрэмжүүлэг, зөвлөгөөг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба /О.Ундрах/, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Амьсгалын замын цочмог халдвар, томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 5 хүртэл насны хүүхэдтэй ажил хөдөлмөр эрхэлж байгаа эцэг, эх, асран хамгаалагчдад тав хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгохыг төсвийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт зөвлөсүгэй.

4. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар өөрийн байгууллагадаа ухуулга, сурталчилгаа хийх, ажилтнуудын дархлааг дэмжих, амны хаалт хэрэглэх, гар угаах болон халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг төрийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт уриалсугай.

5. Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, шаардлагагүй тохиолдолд 16 хүртэл насны хүүхдийг гадагш гаргахгүй байхыг нийт эцэг, эх, асран хамгаалагч нарт уриалсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Бат-Өлзий/, сумын Засаг дарга нарт даалгасугай.



З.БАТЗОРИГ

Захирамж-2020 он А-4

20200051